ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Замын-үүд сумын НААҮ ОНӨ ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДГА-2025/8/НА-СТА-ОНӨҮГ


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Дорноговь аймаг<br>2025 он | Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал,<br>Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий<br>Утас: 7052-2734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn<br>Аудитын менежер: У.Оюунтүлхүүр<br>Утас: 7052-3020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn<br>Ахлах аудитор/Аудитор: З.Ундармаа<br>Утас: 8901-1289 Цахим хаяг: babi.tami.audit@gmail.com<br>Ахлах аудитор/Аудитор: Т.Золбоо<br>Утас: 9111-1254 Цахим хаяг: babi.tami.audit@gmail.com<br>Аудитор: Б.Батчимэг<br>Утас: 9111-0704 Цахим хаяг: babi.tami.audit@gmail.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2025.03.14 № 1-6/305

танай ______________-ны №______________-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН НААҮ ОНӨ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Ө.НАРАНТУЯА ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын НААҮ ОНӨ ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудАд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурьдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Дорноговь аймгийн Замын-Үүд сумын НААҮ ОНӨ ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Замын-Үүд сумын НААҮ ОНӨ ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангаж байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2024 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар,

44250?132

гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, баримтжуулалт, хөрөнгө зарцуулалтын ил тод байдал, худалдан авах ажиллагаар үр дүнтэй зохион байгуулсан эсэх, хөрөнгийн удирдлага зохион байгуулалт зэргийг гол асуудал гэж үзлээ.

Шилэн дансны тухай хуульд заасан цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын гүйлгээнд тухайн сард нь тайлагнаагүй 11 сард нийлүүлж тайлагнасан гүйлгээнүүд байна.

**Бусад асуудлын хэсэг**

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Үлдэгдэл | |
|---|---|---|---|
| | | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
| **1** | **ХӨРӨНГӨ** | | |
| **1.1** | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.01 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 33,155,067.94 | 1,198,342.72 |
| 1.1.02 | Дансны авлага | 27,217,294.00 | 19,124,554.99 |
| 1.1.03 | Татвар, НДШ-ийн авлага | 119,373.26 | 982,943.33 |
| 1.1.04 | Бусад авлага | 458,608.81 | 489,121.89 |
| 1.1.06 | Бараа материал | 9,355,965.00 | 34,560,710.00 |
| **1.1.11** | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **70,306,309.01** | **56,355,672.93** |
| **1.2** | **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| 1.2.01 | Үндсэн хөрөнгө | 2,285,896,398.36 | 1,965,950,028.61 |
| 1.2.02 | Биет бус хөрөнгө | 99,875,000.00 | 99,875,000.00 |
| **1.2.10** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **2,385,771,398.36** | **2,065,825,028.61** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,456,077,707.37** | **2,122,180,701.54** |
| **2** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| **2.1** | **ӨР ТӨЛБӨР** | | |
| **2.1.1** | **Богино хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.1.01 | Дансны өглөг | 3,000,000.00 | 1,444,297.00 |
| 2.1.1.02 | Цалингийн өглөг | 502,902.34 | 1,452,099.25 |
| 2.1.1.03 | Татварын өр | 293,039.78 | 1,777,462. |
| 2.1.1.04 | НДШ-ийн өглөг | 0 | 17,500,000.00 |
| 2.1.1.13 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 3,795,942.12 | 22,173,858.48 |
| **2.2** | **ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН** | **3,795,942.12** | **22,173,858.48** |
| **2.3** | **ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| 2.3.01 | Өмч -төрийн | 5,017,700,907.05 | 5,036,000,907.05 |
| 2.3.08 | Эздийн өмчийн бусад хэсэг | | |
| 2.3.09 | Хуримтлагдсан ашиг | -2,565,419,141.80 | -2,565,419,141.80 |
| 2.3.10 | Тайлант үеийн ашиг, алдагдал | | -370,574,922.18 |
| **2.3.11** | **ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **2,452,281,765.25** | **2,100,006,843.07** |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **2,456,077,707.37** | **2,122,180,701.54** |

### Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | Борлуулалтын орлого /цэвэр/ | **1,128,682,429.00** | **1,613,825,454.55** |
| 2 | Борлуулалтын өртөг | | |
| **3** | **Нийт ашиг /алдагдал/** | **1,128,682,429.00** | **1,613,825,454.55** |
| 8 | Бусад орлого | | 1,968,286.00 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 1,432,388,228.05 | 1,951,548,418.23 |
| 11 | Санхүүгийн зардал | 389,408.37 | 235,603.00 |
| 12 | Бусад зардал | 2,456,349.30 | 3,838,150.00 |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/ | | 30,746,491.50 |
| **12.1** | **Зардлын дүн** | | |
| **18** | **Татвар төлөхийн өмнөх ашиг** | **-306,551,556.72** | **-370,574,922.18** |
| 19 | Орлогын татварын зардал | | |
| **20** | **Татварын дараах ашиг /алдагдал/** | **-306,551,556.72** | **-370,574,922.18** |
| **22** | **Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/** | **-306,551,556.72** | **-370,574,922.18** |

## Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **1,241,557,386.90** | **1,777,056,286.00** |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүсний орлого | 1,239,744,299.90 | 1,775,088,000.00 |
| 1.1.3 | Бусад мөнгөн орлого | 1,813,087.00 | 1,968,286.00 |
| **1.2** | **Мөнгөн зарлагын дүн(-)** | **1,206,074,149.12** | **1,800,835,811.22** |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 601,458,093.88 | 837,060,943.03 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 169,955,845.90 | 195,183,897.27 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авхад төлсөн | 157,273,745.00 | 304,924,022.00 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 23,532,624.31 | 34,816,134.40 |
| 1.2.5 | Түлш, шатхуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | | 75,269,610.00 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 174,487,708.66 | 214,528,693.52 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | 2,013,823.00 | 953,000.00 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 77,352,308.37 | 138,099,511.00 |
| **1.3** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **35,483,23778** | **-23,779,525.22** |
| **2** | **Хөрөнгө оруулалтын үйл ажилллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | | |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | **2,550,000.00** | **8,177,200.00** |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 2,550,000.00 | 8,177,200.00 |
| **2.3** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **-2,550,000.00** | **-8,177,200.00** |
| **3** | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн (+) | | |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | **201,000.00** | |
| 3.2.1 | Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 201,000.00 | |
| **3.3** | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **-201,000.00** | |
| **4** | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **32,732,237.78** | **-31,956,725.22** |
| **5** | **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **422,830.16** | **33,155,067.94** |
| **6** | **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **33,155,067.94** | **1,198,342.72** |

## Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Үзүүлэлт | Өмч | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл** | **4,894,481,140.10** | | **-2,238,944,800.07** | **2,655,536,340.03** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | -19,922,785.00 | -19,922,785.00 |
| Залруулсан үлдэгдэл | | | | |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | -306,551,556.53 | -306,414,627.93 |
| Өмчид гарсан өөрчлөлт | 123,219,766.95 | | | 123,219,766.95 |
| **2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл** | **5,017,700,907.05** | | **-2,565,419,141.60** | **2,452,281,765.45** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | |
| Залруулсан үлдэгдэл | | | | |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | -370,574,922.18 | -370,574,922.18 |
| Өмчид гарсан өөрчлөлт | 18,300,000.00 | | | 18,300,000.00 |
| **2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл** | **5,036,000,907.05** | | **-2,935,994,063.79** | **2,100,006,843.26** |

## Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

| Д/д | Зардлын нэрс | 2024 оны төлөвлөгөө | 2024 оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| Нийт бараа ажил үйлчилгээний орлого | | 1,982,368,528.00 | 2,042,887,800.00 |
| Нийт бараа ажил үйлчилгээний зардал | | 1,982,368,528.00 | 2,124,763,704.99 |
| Ашиг алдагдал | | | (81,875,904.99) |
| Нийт орлого | | | |
| 1 | Санхүүжилтийн орлого | 1,700,000,000.00 | 2,012,825,300.00 |
| | | | |
| 2 | Үйл ажиллагааны орлого | 282,368,528.00 | 30,062,500.00 |
| 1 | Том оврын автомашины зогсоолын орлого | 245,000,000.00 | 21,182,500.00 |
| 2 | Цэвэр усны орлого | 5,500,000.00 | 8,880,000.00 |
| 3 | Механизмын орлого | 25,000,000.00 | |
| 4 | Үйлчилгээний орлого/бункер/ | 3,600,000.00 | |
| 5 | Бусад орлого/гэрлийн шонгийн төлбөр/ | 2,800,000.00 | |
| 6 | Хүүгийн орлого | 468,527.00 | |
| Нийт зардал | | 1,982,368,527.56 | 2,012,825,300.00 |
| 1 | Хог тээврийн ажилчдын цалин | 1,362,342,300.00 | 1,312,342,000.00 |
| 2 | Нийгмийн даатгалын шимтгэл | 170,292,787.56 | 170,292,700.00 |
| 3 | Түлш шатахуун | 166,089,360.00 | 183,927,500.00 |
| 4 | ТӨГАҮ | 77,110,880.00 | 172,163,100.00 |
| 5 | Нормын хувцас хэрэглэл | 40,315,000.00 | 35,000,000.00 |
| 6 | Төрийн өмчийн татвар, даатгал хураамж | 12,380,000.00 | 9,100,000.00 |
| 7 | Урсгал засвар шаардлагатай сэлбэгт | 120,000,000.00 | 130,000,000.00 |
| 8 | Тос масло | 33,838,200.00 | - |

## 3.Аудитын илрүүлэлт

Аудитаар 1 зөрчил илрүүлснээс 1 зөвлөмж өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

### 3.2 Албан шаардлага

2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага тогтоогдоогүй болно.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Шилэн дансны тухай хуульд заасан цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын гүйлгээнд тухайн гүйлгээ гарсан сард нь тайлагнаагүй 11 сард нийлүүлж тайлагнасан гүйлгээнүүд байна.

*Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансанд мэдээллийг гүйлгээ гарсан  тухай сард нь байршуулж байх, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Мэдээлэл хоцроож тайлагнасан | 1 | 0.0 | - | - | - | - | 1 | 0.0 |
| **Дүн** | **1** | **0.0** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **0.0** |